



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2023 – 12 САР | ДУГААР 61

ГАРЧИГ

1–3	Бодлогын нийтлэл
4–8	Зохицуулалтын мэдээ
9–10	Байр суурь
11–12	Тайлбар зөвлөмж
13–14	Тогтвортой санхүүжилт
15–16	Компанийн засаглал, комплайнс
17–18	Финтек ба регтек
19–27	Судлаачийн индэр
28–29	Үл хөдлөх хөрөнгө худалдан авахдаа юуг анхаарах хэрэгтэй вэ?
30–31	Олон улсын зах зээлийн мэдээ
32	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ /БРОКЕР/-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах зохицуулалтын орчныг бүрдүүлэхээр холбогдох ажлуудыг гүйцэтгэж байна. Тухайлбал Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд Санхүүгийн зохицуулах хороо батлахаар заасан 4 харилцааг зохицуулсан 3 журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран 1 журмыг хамтран тус тус баталсан бол уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаатай холбоотой 11 харилцааг зохицуулсан 7 журам мөрдүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК–д зөвшөөрсөн.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 59 дүгээр тогтоолоор заасны дагуу уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг “Монголын хөрөнгийн бирж” ХК–аар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн тул Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 385 дугаар тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК–д уг тусгай зөвшөөрлийг олгосон бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа тус биржээр дамжин амжилттай явагдаж байна.

Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”–ын дагуу нүүрсний цахим арилжаа “Монголын хөрөнгийн бирж” ХК–аар дамжуулан 2023 оны 01 дүгээр сарын 12–ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 29–ний өдрийг хүртэлх хугацаанд 54 удаа амжилттай зохион байгуулагдаж, нийт 486 багц буюу 3,110,400 тн нүүрсийг нийт 1.31 их наяд төгрөгөөр арилжаалсан.

Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг тогтоосон (хүснэгт 1) бөгөөд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК–аар дамжуулан 2023 оны 7 дугаар сарын 26–ны өдрөөс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 9.3 сая орчим тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 4.5 гаруй их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

Үргэлжлэл 2–р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ТӨРИЙН АЛБА

Төрийн алба Төрийн албаны тухай хуулиар тогтоосон дүрэм журмаар эрх, үүрэг нь зохицуулагддаг албан хаагчдаас бүрдсэн алба.



CIVIL SERVICE /PUBLIC SERVICE

A body composed of those public servants that are subject to the rules and regulations defined in the Civil Service Statute.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ /БРОКЕР/–ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

Эхлэл нь 1–р нүүрт

Хүснэгт. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал

№	Бүтээгдэхүүний нэр	Төрөл	Ангилал
1	Хайлуур жонш	Хүдэр Баяжмал	Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолын хавсралтын 2.2, 2.2', 2.4, 2.4'–д заасан ангиллын дагуу тооцно.
2	Төмөр	Хүдэр Баяжмал	
3	Нүүрс	Боловсруулаагүй Баяжуулсан	

Арилжааны үр дүнд бүтээгдэхүүний үнэ дунджаар 10 гаруй хувийн өсөлттэй арилжаалагдаж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч компаниудын орлогыг нэмэгдүүлсэн эерэг үр дүнг авчирсан.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд биржийн арилжааг уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (цаашид “брокер” гэх)–аар дамжуулан зохион байгуулахаар заасан хэдий ч энэ оныг дуустал хугацаанд арилжааг брокерын оролцоогүйгээр явуулах боломжтой байдлаар зохицуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дээрх брокерын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхлэх сонирхолтой этгээдүүдэд зориулж уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахтай холбоотой мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг 4 удаа зохион байгуулсан. Үүний үр дүнд Санхүүгийн

зохицуулах хорооны зүгээс дээрх үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 компанид олгоод байгаа бөгөөд цаашид ч уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зах зээлийг хөгжүүлэхэд анхаарч ажиллахаар зорьж байна.

Үүний хүрээнд энэ удаагийн бодлогын нийтлэлээр дамжуулан та бүхэнд “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)–ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам”–ын ерөнхий болоод онцлох зохицуулалтуудын талаар хүргэж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 186 дугаар тогтоолоор баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)–ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам”–д зааснаар брокер нь дараах шаардлагуудыг хангах шаардлагатай.

Үүнд

- ◆ Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 3.5 тэрбум төгрөгөөс доошгүй байх;
- ◆ Эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд байх;
- ◆ Бирж, тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, программ хангамжийн шаардлагыг тус тус хангасан байх;
- ◆ Үндсэн үйл ажиллагааг явуулах нэгжтэй байх;
- ◆ Эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм журам нь тодорхой, энэ чиглэлээр мэргэжил, туршлагатай хүний нөөцтэй байх;
- ◆ Мэдээлэл технологи, программ хангамжийн стандартуудыг мөрдөх;
- ◆ Үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан ажлын байртай байх;
- ◆ Одоогийн ҮЦК-ийн хувьд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчид тавигдах шалгуурыг хангаж байна.

Харин брокерын хувьд дараах бүтэц зохион байгуулалттай байхаар зохицуулсан. Үүнд:

- ◆ Үндсэн үйл ажиллагааг явуулах нэгжтэй байх;
- ◆ Мэдээлэл, технологийн бие даасан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;
- ◆ Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;
- ◆ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт болон комплаенсын хяналтыг хэрэгжүүлэх нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байх;
- ◆ Эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм журам нь тодорхой, энэ чиглэлээр мэргэжил, туршлагатай хүний нөөцтэй байх.

Мөн брокерын эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байхаар зохицуулсан. Үүнд:

- ◆ Нэгжийн удирдах албан тушаалтан нь уул уурхай, санхүүгийн салбарт хоёроос доошгүй жил ажилласан туршлагатай, бусад мэргэжилтэн нь уул уурхай, хууль, худалдаа, санхүү, эдийн засаг, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн байх;
- ◆ Тухайн компанид үйлчилгээ үзүүлдэг үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө, хөрөнгийн үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд биш байх;

- ◆ Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэх удирдлага нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;
- ◆ Гүйцэтгэх удирдлага нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах бөгөөд мэргэжилтэн нь ял шийтгэлгүй, компанийн үндсэн ажилтан байх;
- ◆ Хуульд өөрөөр заагаагүй бол давхар ажил хавсран эрхэлдэггүй байх;
- ◆ Гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь уул уурхай, санхүү, үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;
- ◆ 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай брокерын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд мэргэжилтний 70–аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэдээс бүрдсэн байх.

Брокер нь уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр харилцагчийг тогтмол хангаж, харилцагчийн арилжааг гүйлгээний төрөл, хэмжээний хувьд зах зээлийг харгалзан үзсэний үндсэн дээр байж болох хамгийн сайн нөхцөлтэйгөөр гүйцэтгэх зарчмыг баримтална. Мөн брокер нь талуудын харилцан тохиролцоогүй нөхцөлөөр хийгдсэн, хамгийн сайн гүйцэтгэлийн нөхцөлөөр хийсэн, бусад байгууллагын хураамжийн түвшнээс доогуур байхаас бусад тохиолдолд өөрийн холбоотой этгээдээр дамжуулан харилцагчийн нэрийн өмнөөс арилжаа хийхгүй ба хууль тогтоомжийн дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой хийсэн судалгаа, өгсөн зөвлөгөө болон авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг таваас доошгүй жилийн хугацаагаар болон бүртгэлийг аюулгүй найдвартай хадгалах үйл ажиллагааг дотоод дүрэм, журмаар тодорхой зохицуулсан байхаар уг журамд тусгасан.

Үүнээс гадна брокерын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх, эрх бүхий албан тушаалтныг томилох, гүйцэтгэх удирдлагыг өөрчлөн томилох, оноосон нэр өөрчлөх, оршин байгаа газрын хууль ёсны хаяг өөрчлөгдөх зэрэг тохиолдлуудад Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг оруулах шаардлагатай юм.

Түүнчлэн брокер нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон энэ журамд заасан мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүйгээр тогтоосон хугацаанд болон тухай бүрд Санхүүгийн зохицуулах хороо, харилцагч болон олон нийтэд хүргэх бөгөөд брокерын хувьд гүйцэтгэх удирдлага нь мэдээлэл, тайлагналд хяналт тавихаар зохицуулсан.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН АНХНЫ НОГООН БОНДЫН АРИЛЖАА ЭХЭЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн зах зээл, ялангуяа хөрөнгийн зах зээлийг тогтвортой, ногоон хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн хөгжүүлэх, тогтвортой санхүүжилтийн олон улсын стандартыг зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр санал санаачилга гарган, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2019 онд “Монгол Улсын ногоон таксономи”-ийг баталсны үр дүнд Монгол Улс ногоон таксономиг баталсан дэлхийн анхны улсуудын нэг болсон. Түүнчлэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл Үндэсний тогтвортой санхүүжилтийн замын зураг”-ийг, энэ онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан “Тогтвортой санхүүгийн долоо хоног 2023” арга хэмжээний үеэр “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи”-ийг тус тус баталснаар Монгол Улс ногоон санхүүжилтийн тогтолцоог бий болгож, энэ хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, туршлагаараа олон улсад тэргүүлэгч улсуудын нэг гэдгээ дахин харуулсан юм.

Хөрөнгийн зах зээл дээр ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг гарах, хөгжүүлэхэд Санхүүгийн зохицуулах хороонцгой анхаарч, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, ногоон хөрөнгө оруулалт татах бололцоог бүрдүүлэх чиглэлээр 2021 онд бондын бүртгэлийн зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсэн. Энэхүү зохицуулалтаар компаниуд тодорхой үнийн дүн бүхий бондыг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг өөрийн онцлогт нийцүүлэн хэсэгчлэн гаргах “Бонд гаргах хөтөлбөр” хэрэгжүүлэх боломжтой болсон бол санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгон барьцаагүйгээр бонд гаргах,

ялангуяа “Ногоон бонд” гаргах харилцааг илүү уян хатан, дэмжсэн зохицуулалтыг бий болгосон.

Түүнчлэн, өнгөрсөнд Санхүүгийн зохицуулах хороо Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн зохицуулалтын шинэчлэлийг хийснээр компаниуд, үнэт цаас гаргагчид зөвхөн хөрөнгийн биржээс гадна биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд ногоон бондыг шуурхай, зохицуулалтын уян хатан орчинд гаргах давуу боломжтой болсон юм. Дээрх зохицуулалтуудын үр дүнд системийн нөлөө бүхий банкуудын нэг болох “ХААН банк” ХК-аас нийтэд санал болгон гаргаж буй Монгол Улсын анхны ногоон бондыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн бөгөөд тус бондын анхдагч зах зээлийн арилжаа эхэлж буй нь хөрөнгийн зах зээлд томоохон онцлох үйл явдал болж байна.

“ХААН банк” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй ногоон бонд нь хөтөлбөрийн хүрээнд төгрөгийн болон ам.долларын хосолсон хэлбэрээр гарах бөгөөд олон улсын “Sustainable Fitch” байгууллагаар ногоон бондын зарчмуудтай нийцсэн талаарх дүгнэлт гаргуулснаар онцлох шинэ бүтээгдэхүүн болж байна. Энэ удаа 36 сарын хугацаатай, 16 хувийн хүүтэй, 170,000 ширхэг бондыг гаргажнийт 17.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, ногоон санхүүжилтийн зээлийн багцаа нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр үнэт цаасны танилцуулгадаа тусгажээ.

АЗИ НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛГИЙН 2023 ОНЫ ТИПОЛОГИЙН ХУРАЛД МОНГОЛ УЛС ТУРШЛАГА ХУВААЛЦЛАА

Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн энэ оны ээлжит “Типологи, хүний нөөцийг чадавхжуулах семинар” Энэтхэг Улсын Нью-Дели хотноо 11 дүгээр сарын 28-наас энэ сарын 1-ний өдрүүдэд боллоо. Семинарын “Виртуал хөрөнгө ба виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээ” сэдэвт хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны албан хаагчид панелистаар оролцож, Монгол Улс дахь виртуал хөрөнгийн салбарын эрсдэлийн үнэлгээний үр дүн болоод зохицуулалтын сайн туршлагын талаар илтгэл тавилаа.

Жил бүр зохион байгуулагддаг тус типологийн семинараар гишүүн орны төлөөлөгчид, салбарын мэргэжилтэн, экспертүүд мөнгө



угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх олон улсын чиг хандлага, бодлого зохицуулалтын асуудлууд, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд олон улсын хамтын ажиллагааг сайжруулах арга замуудын талаар хэлэлцэж, мэдлэг туршлагаа хуваалцдаг юм. Энэ жилийн типологийн хурлын онцлох сэдэв нь шинэ технологи болон виртуал хөрөнгийн салбарыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт врвуулан ашиглах эрсдэлийг бууруулах, энэ салбарын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлд төвлөрсөн бөгөөд улс орнууд дээрх чиглэлд онцгой ач холбогдол өгч ажиллаж байгааг хэлэлцүүлгийн үеэр илэрхийлсэн.

Семинарт Монгол Улсыг төлөөлж Санхүүгийн зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар, арилжааны банкуудын төлөөллүүд оролцсон ба Монгол Улсын шинэ технологи, виртуал хөрөнгийн салбартай холбоотой бодлого зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээг онцлон, туршлага хуваалцсан юм.



"САНХҮҮГИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА БА СОРИЛТ" УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Хөрөнгийн зах зээл хөгжихийн хэрээр түүнийг дагаад санхүүгийн мэдээллийн ил тод байдал, мэдээллийн чанарыг шийдвэрлэхэд санхүүгийн мэргэжилтнүүдийн үүрэг оролцоо чухал билээ.



Иймд Санхүүгийн зохицуулах хороо МУИС-ын Бизнесийн сургуультай хамтран "Санхүүгийн орчин үеийн чиг хандлага ба сорилт" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Монгол Улсад Санхүүгийн байгууллага үүсэн байгуулагдсаны 112 жилийн ой, Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны өдөр-ийг тохиолдуулан зохион байгуулж буй энэхүү уулзалт хэлэлцүүлгээр Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал "Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал" сэдвээр илтгэл тавьж, оюутан, залуусын сонирхсон асуултад хариулт өгөв.

Мөн МУИС-ийн Бизнесийн сургуулийн тэнхимийн ахлах багш доктор Г.Гүнбилэг "Зан төлөвийн санхүү", "Ард Кредит ББСБ" ХК-ийн санхүү эрхэлсэн захирал Б.Лхагвасүрэн "Санхүүгийн зах зээлийн ирээдүйн чиг хандлага" сэдвээртус тус илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Олон улсын санхүүгийн корпорацын Монгол Улс дахь суурин төлөөлөгч Руфат Алимардановоор ахлуулсан төлөөлөгчидтэй уулзлаа.

Энэ үеэрхоёр тал хамтран хэрэгжүүлж буй “Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”, “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”-ийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл солилцож, цаашдын хамтын ажиллагааныхаа талаар санал солилцлоо. Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчин, банк бус санхүүгийн байгууллагуудын ногоон зээлийн үйлчилгээний талаар болон энэ онд хийсэн онцлох ажлуудын үр дүнгээс танилцуулсан юм. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбаруудын үйл ажиллагааны өсөлт, амжилтыг хэвээр хадгалах, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг улам нэмэгдүүлэх, олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхийн төлөө Олон улсын санхүүгийн корпорац цаашид ч хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ, КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНӨЛӨӨ

Компанийн засаглалын тогтолцоо, комплайнсыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нь аливаа байгууллагын урт хугацааны тогтвортой хөгжлийг, цаашлаад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангагч суурь нөхцөл мөн. Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын салбаруудад компанийн засаглалын тогтолцоог сайжруулах, комплайнсын үр дүнтэй хяналтыг нэвтрүүлэх зорилгоор Санхүү, эдийн засгийн их сургууль болон “Санхүүгийн боловсролын зангилаа” ТББ-тай хамтран “Компанийн засаглалын кодексын хэрэгжилт, комплайнсын эрсдэлийн удирдлага” нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлэлцүүлгийг нээж, “Хороо 2007 онд “Монгол Улсын компанийн



засаглалын кодекс”-ийг анх баталж байсан бол 16 жилийн дараа буюу өнгөрсөн онд шинэчилсэн. Улмаар энэ онд кодексын хэрэгжилтийг үнэлж, салбарын зэрэглэл тогтоох ажлыг зохион байгуулсны үр дүнд зохицуулалттай нийт гурван салбарт кодексын хэрэгжилт дунджаар 14.1 хувиар өссөн бол хувьцаат компаниудын үнэлгээ 17.1 хувийн ахиц дэвшлийг үзүүлээд байна.



Өнөөдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа нь нэг талаас, Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага/ФАТФ/-ын зөвлөмжийн хэрэгжилтийг баталгаажуулах, ахиулах нөгөө талаас зохицуулалттай этгээд комплайнсын эрсдэлээ өөрөө үнэлж, удирдах байгууллагын соёлыг нутагшуулахад чухал ач холбогдолтой” гэдгийг онцолсон юм.

“САНХҮҮГИЙН ИННОВАЦ ТЕКСПРИНТ- 2023” ЯЛАГЧДАА ТОДРУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “Санхүүгийн инновац текспринт-2023” уралдаан амжилттай болж өнгөрлөө.



Энэ уралдаан нь санхүүгийн салбар дахь инновацыг дэмжих, олон нийтэд технологид суурилсан санхүүгийн зах зээл болон сэндрокс зохицуулалтын үйл ажиллагааг таниулах, санхүүгийн зах зээл дэх тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд технологийн дэвшлийг ухаалгаар ашиглах зорилготой. Уралдаанд 22 багийн 100 гаруй залуус бүртгүүлсэн бөгөөд өгөгдсөн сэдвийн хүрээнд шинэлэг санаагаа боловсруулах, онлайн менторуудтай уулзах, "MOffice" хамтын оффист 72 цагийн туршид хөгжүүлэлт хийх зэрэг үе шатуудыг даван шилдэг 9 багийн 32 оролцогч өөрсдийн хөгжүүлсэн шинэлэг санаа, инновац шийдлээ энэ сарын 03-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо дээр хэлэлцүүлэн шилдгүүдээ тодрууллаа. Үүнд:

Нэгдүгээр байрт "Stood" багийн хөгжүүлсэн дундын хуримтлалын gaming аппликэйшн;

Хоёрдугаар байрт "Visionaries" баг санхүүгийн залиланг илрүүлэх E-scam.mn платформ;

Гуравдугаар байрт "AI Rookies" баг санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилго бүхий Promo аппликэйшнаар тус тус шалгаран шагналт байруудыг эзэллээ.

Текспринт уралдаан нь салбарын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд инновац, технологийг ашигласан ухаалаг, шийдлийг эрэлхийлэх зорилгоор санхүүгийн салбарт зохион байгуулагдаж эхэлсэн шинэлэг, бүтээлч арга хэмжээ бөгөөд энэ жил анх удаагаа Монгол Улсад зохион байгуулагдсанаараа онцлог юм.

"Санхүүгийн инновац текспринт-2023" уралдааныг сэндроксын орчинд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг туршиж буй компаниуд



болон "Мобифинанс ББСБ" ХХК, "Мони маркет фанд" ХХК, "Монре даатгал" ХХК, "Зээл эм эн платформ ББСБ" ХХК, "Финберри" ХХК-уудын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Мөн уралдааны хамтран зохион байгуулагчаар "Анрид Мэдиа", мэдиа хамтрагчаар "Лемон Пресс" хамтран ажилласан юм.

БООГИЙН ДӨРӨВ ДЭХ УДААГИЙН "НЭГ БҮС, НЭГ ЗАМ" БАГА ХУРАЛ БОЛЛОО

БНХАУ-ын Хайнань мужид 11 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Бөөгийн дөрөв дэх удаагийн "Нэг бүс, нэг зам" санхүүгийн



бага хурал амжилттай болж өндөрлөлөө. БНХАУ-ын "Нэг бүс, нэг зам" санаачилга нь Торгоны замын эдийн засгийн бүс, XXI зууны далайн торгоны замын бүсэд хамаарах хөгжлийн стратеги бөгөөд уг санаачилгад багтсан улсуудын эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, аливаа нөөц баялгийг чөлөөтэй нэвтрүүлэх зорилготой юм. Энэ удаагийн арга хэмжээнд Хятадын дотоодын банк санхүүгийн байгууллагууд, үнэт цаасны компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулагчид, аж үйлдвэр болон худалдааны байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгч зэрэг мянга гаруй төлөөлөл оролцлоо.

САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА (ФАТФ) – АЗИ, НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛЭГ (АНДМУТБ)-ИЙН ХАМТАРСАН ҮНЭЛГЭЭЧНИЙ СУРГАЛТ БОЛЛОО

Дэлхийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт тогтоогч байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж, стандартыг 200 гаруй улс орон хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсэн бөгөөд



харилцан үнэлгээний үр дүнд үндэслэн өндөр эрсдэлтэй улс орнуудыг тодорхойлж “саарал ба хар жагсаалт”-д оруулдаг. Тус харилцан үнэлгээг Глобал сүлжээний гишүүдээс бүрдсэн олон улсын шинжээчдийн баг хийж гүйцэтгэдэг.

2023 оны 11 дүгээр сарын 20–24-ний өдрүүдэд Канад улсын Оттава хотноо ФАТФ – Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хамтарсан үнэлгээчний сургалтыг зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтад Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны ахлах хянан шалгагч Б.Цолмонтуяа, хянан шалгагч Г.Ивээл нар амжилттай хамрагдаж, олон улсын үнэлгээ хийх шинжээчдийн багт ажиллах эрхтэй боллоо. Ингэснээр Санхүүгийн зохицуулах хорооноос ФАТФ-ын зөвлөмж, стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнтэй байдлыг тодорхойлох олон улсын шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд ажиллах эрхтэй хоёр шинжээчтэй болж байгаа юм.

ХОНКОНГИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТӨРИЙН САНГИЙН ХОРОО БОЛОН ХОНКОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Хонконгийн Санхүүгийн үйлчилгээ, төрийн сангийн хороо (FTSB)-ны нарийн бичгийн дарга Christopher Hui-тай Хонконг, Макао дахь Монгол Улсын Ерөнхий консул О.Хулан болон бусад албаны төлөөллийн хамт албан уулзалт хийлээ. Энэ үеэр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны талаар танилцуулж, Хонконгийн зах зээлээр дамжуулж Хонконг болон олон улсаас хөрөнгө оруулалт татах, гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголын хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх хүрээнд хоёр тал харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар ярилцлаа.

Мөн Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон Хонконг, Макао дахь Монгол Улсын Ерөнхий консулын газрын төлөөллүүд Хонконгийн хөрөнгийн биржийн (HKEX) олон улсын бизнесийн харилцааны захирал Silvia Chen болон олон улсын үнэт цаас гаргагчийн үйлчилгээний дэд захирал Jacqueline Jiang нартай албан уулзалт хийлээ. Уулзалтаар монголын аж ахуйн нэгж компаниудыг Хонконгийн хөрөнгийн бирж дээр давхар бүртгүүлэх, олон улсын зах зээлээс хөрөнгө босгох, Хонконгийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг “Recognized Stock Exchange” статустай болгох хүрээнд санамж бичиг байгуулахаар боллоо.



БАЙР СУУРЬ

ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

“Сэндли ББС” ХК-ийн Мөнгөн гуйвуулга хариуцсан захирал Б.Нямжаргал



замаар илгээдэг байсан бол технологи хурдтай хөгжиж, дижитал хэлбэрт шилжин иргэд цахимаар хормын дотор гэр бүл, эх орон руугаа мөнгө шилжүүлэх боломжтой болсон.

Энэ боломжийг бүрдүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахаар Sendly олон улсын мөнгөн гуйвуулгын аппликейшн нэг хэсэг нь болж ажиллаж байгаадаа баяртай байна.

Монгол Улсын хувьд мөнгөн гуйвуулга хүлээн авагч орон бөгөөд мөнгө шилжүүлж эхэлсэн 1998 онд 5.5 сая ам.доллар, 2000 он хүртэл 1.0 сая ам.доллар шилжүүлж байсан бол үүнээс хойш тасралтгүй нэмэгдэж, 2019 онд 561 сая ам.доллар эх орон руугаа шилжүүлсэн нь түүхэн дээд хэмжээнд хүрсэн байдаг. Ковид-19 цар тахалтай холбоотой дэлхий эдийн засгийн нөхцөл байдлын улмаас 2020 оноос энэ тоо буурсан байгаа юм. Sendly аппликейшны хувьд 2020 онд анхны олон улсын гарцаа нээж, АНУ-аас Монгол чиглэлд гуйвуулгын үйлчилгээ үзүүлж эхэлсэн нь цаг үеэ мэдэрч чадсан хамгийн зөв сонголт болсон гэсэн үг. Тэр цагаас хойш бид зах зээлээ тэлж Австрали, Япон, БНХАУ болон Европын 27 орноос Монгол чиглэлд, Монголоос дэлхийн 170 гаруй улс, бүс нутаг руу ердөө 1–10 минутын дотор гуйвуулгын үйлчилгээ үзүүлж байна. 2022 оны Дэлхийн банкны судалгаагаар Хилийн чанадад байгаа Монголчууд маань 399.0 сая ам.долларыг эх орон руугаа шилжүүлсэн байна гэж гарсан. Энэ дүнгийн 8.26 сая ам.доллар буюу 26.07 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын гүйлгээг манай аппликейшнаар дамжуулан гадаадаас шилжүүлсэн байгаа юм.

Дэлхий нийтээр дижитал хэлбэрт шилжих болсон энэ цаг үед Монголын компаниуд ч хүний хэрэгцээ шаардлагыг илүү хялбарчилж, илүү хүртээмжтэй байдлыг бий болгохыг зорилгоо болгон ажиллах болсон. Тэдгээрийн нэг болох “Сэндли ББСБ” ХК нь санхүү, технологийг хослуулан уламжлалт болон финтек чиглэлээр ажилладаг бөгөөд бүтээгдэхүүн үйлчилгээнийх нь нэг болох олон улсын мөнгөн гуйвуулгын Sendly аппликейшны талаар тус компанийн мөнгөн гуйвуулга хариуцсан захирал Б.Нямжаргалаас тодрууллаа.

Sendly олон улсын мөнгөн гуйвуулгын аппликейшны тухайд мэдээлэл өгвөл?

Дэлхийн банкнаас гаргасан судалгаанаас харахад Монголчууд 1998 оноос эхлэн хилийн чанадаас эх орон руугаа мөнгө шилжүүлж эхэлсэн байдаг. Тухайн үед гараас гарт буюу хувь хүмүүс хоорондоо ямар нэгэн хяналтгүйгээр мөнгө солилцох

2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Sendly аппликейшныг 71 мянга гаруй хэрэглэгч татаж, идэвхтэй хэрэглэгчийн тоо 30 мянгад хүрсэн. Мэдээж манай баг хамт олон энэ үзүүлэлтийг илүү өсгөхийг зорьж байгаа. Бид ирэх онд маш олон ажил төлөвлөсөн бөгөөд түүндээ хүрэхийг зорьж ажиллаж байна.

1998	1999	2000	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
5.5	7.8	1.0	199.0	261.0	260.0	273.0	440.0	561.0	549.0	471.0	399.0

Гадаадад ажил хөдөлмөр эрхлэгчдийн ар гэртээ илгээсэн мөнгөн дүн / сая ам.доллаароор тооцно.

Эх сурвалж: Дэлхийн банк 2022 он

Sendly ОУ-ын мөнгөн гуйвуулгын аппликейшны ялгарах онцлог юу вэ?

Манай аппликейшны хувьд 100 хувь Монгол хүний бүтээсэн, хөгжүүлсэн Монголдоо анхдагч мөнгөн гуйвуулгын программ гэж хэлж болно. Ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй компаниуд дундаас хамгийн бага шимтгэл, хурдан шуурхай, найдвартай, эрсдэлгүй гэдгээрээ манай аппликейшныг сонгох нэг шалтгаан болох болов уу. Мөн бид дэлхийн томоохон компаниуд болох Их Британийн Paysend PLC, Machnet LTD, Golden Money transfer, City ex-press, Paytop, БНХАУ-ын Tencent group-ын “Wechat pay” болон тус улсын хамгийн том цахим төлбөрийн платформ болох 1 тэрбум гаруй хэрэглэгчтэй Ant group-тэй албан ёсны эрхтэй хамтарч ажиллаж байна. Манай хамтрагч байгууллагууд бүгд ISO болон PCI/DSS Олон улсын стандартыг хангасан. Бид ч мөн энэ оны нэгдүгээр улиралд Мэдээллийн Аюулгүй байдал Менежментийн Тогтолцооны ISO27001:2013 стандартыг амжилттай нэвтрүүлж, БНЭУ-ын QFS байгууллагаас гэрчилгээгээ гардаж авлаа. Ингэснээр хэрэглэгчдийн хувийн мэдээлэл болон банкны дансны аюулгүй байдлыг найдвартай хамгаалж, хангаж ажиллаж байгаа гэсэн үг. Sendly аппликейшн дан ганц мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлээд зогсохгүй, гадаадад байгаа монголчууд манай аппликейшнаар дамжуулан Сайн дурын нийгмийн даатгал төлөх, үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох, онлайн худалдаа хийх, өөрийн нэр дээрх төгөлтэй болох зэрэг олон боломжуудыг бүрдүүлснээр нь бусад мөнгөн гуйвуулгын аппликейшнаас онцолж болно.

Та бүхэн санхүүгийн салбарт, финтекийн хөгжилд мэдээж илүү том зорилго тавин ажиллаж байгаа байх. Цаашдын зорилгоосоо хуваалцвал:

Бид 2024 ондоо БНСУ-ын зах зээлд үйлчилгээгээ нэвтрүүлэхээр /FSS буюу Financial Supervisory Service/-оос тусгай зөвшөөрлөө амжилттай аваад байна. Одоогоор бид хөгжүүлэлтийн ажилдаа явж байна. Монгол Улсын 150 мянга гаруй иргэн гадаадад ажиллаж амьдарч, суралцаж байна. ГХЯ-ын мэдээллээр дээрх хүмүүсийн 40 орчим мянга нь БНСУ-д байна гэсэн тоо гарсан. Тэгэхээр бид БНСУ-н зах зээлд үйлчилгээгээ нэвтрүүлж чадвал гадаадад суугаа нийт Монголчуудын 50-иас дээш хувьд хүрч ажиллах боломж бүрдэнэ. Мэдээж цаашлаад АНЭУ, Казакстан зэрэг орнуудын зах зээлд хүрч ажиллахаар зорьж байна.

Анхны зах зээлдээ нэвтэрч байсан үеийн Sendly аппликейшныг олонд танигдаж, өнөөдрийн Sendly болох хүртэл мэдээж олон бэрхшээлтэй тулгарсан байх?

Шинээр гарч ирсэн стартапуудын хувьд хэрэглэгчдэд эрхэлж буй үйл ажиллагаа албан ёсны, эрсдэлгүй, энэ үйлчилгээг үзүүлэх бүрэн дүүрэн нөөц бололцоотой шүү гэдгээ харуулж, танигдах нь хамгийн чухал сорилт байдаг. Манай хамт олон энэ давааг даваад идэвхтэй хэрэглэгчдийнхээ тоог 30 мянгад хүргэж чадсан байна. Sendly аппликейшнаар энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 10.8 сая ам.долларын буюу 35.5 тэрбум төгрөгийн 31.4 мянган гүйлгээ амжилттай хийгдсэн. Гэхдээ бид энэ тоонд ханах биш илүү хичээн ажиллаж, илүү олон мянган хүнд хүртээмжтэй байдлаар үйлчилгээгээ хүргэж ажиллахыг хүсэж байна.

ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

“ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ” –ЫН ТАЛААР

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, олон улсын стандарт, чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдал, дээрх журам зааврын хэрэгжилтийн үр дүн, даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдоос ирүүлсэн санал зөвлөмж, тэдгээрт хийсэн судалгаа шинжилгээнд тулгуурлан даатгагчийн төлбөрийн чадварыг эрсдэлд суурилсан аргачлалаар тодорхойлох, эрсдэлийн үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 09–ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталж, тус журмыг ЗХХА–ын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Тус журмыг даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, зохистой харьцааг эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцоолох, тайлагнах, хянахтай холбоотой шинэчлэн найруулж дараах гол өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд:

ЖУРАМД ОРСОН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД:

1

Урт хугацааны даатгагч болон ердийн, давхар даатгагчийн хувьд зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг ялгаатай байдлаар тооцоолох зохицуулалт:

Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа буюу даатгагч таамаглаж буй өөрт учирч болзошгүй эрсдэлийг даван гарахуйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг харуулах үзүүлэлтийг даатгагчийн өөрийн хөрөнгө болон Зайлшгүй байх хөрөнгийн харьцаагаар тодорхойлно. Зайлшгүй байх хөрөнгийг ердийн болон давхар даатгагчийн хувьд Эрсдэлд суурилсан хөрөнгө болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/–

ийн доод хэмжээний аль ихээр, урт хугацааны даатгагчийн хувьд эрсдэлд суурилсан хөрөнгийн 150 хувьтай тэнцэхүйц хэмжээтэй байна. Амьдралын даатгал нь ердийн даатгалтай харьцуулахад хураамжийн орлогын харьцангуй өндөр хувиар нөөц сан байгуулдаг, манай улсын хувьд урт хугацааны даатгалын зах зээл хангалттай нэвтэрч, тогтворжоогүй, зохицуулалтын хүрээнд дэмжих шаардлагатай гэж үзсэн тул даатгагчдын саналыг үндэслэн зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг ялгаатай байдлаар тооцохоор тусгасан.

2

Зах зээлийн эрсдэлд хамаарах Хүүгийн эрсдэлийн хувийг “Хөрөнгө өр төлбөрийн хугацааны зөрүү”-нд үндэслэн тооцоолох зохицуулалт:

Зах зээлийн эрсдэлийн хувьд зах зээл дэх үнийн өөрчлөлтийн улмаас даатгагчийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлөх хүүгийн, валютын ханшийн, хувьцааны, хөрөнгийн эрсдэлийг авч үзсэн. Даатгагчийн хөрөнгө байршуулсан болон өр төлбөрийг буцаан барагдуулах хугацаа нь хоорондоо уялдаатай байх шаардлагатай ба даатгагчийн урт хугацааны хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор даатгагчдын саналыг үндэслэн хөрөнгө, өр төлбөрийн хугацааны зөрүүнээс хамааран 1–ээс дээш жилийн хугацаатай, тодорхой хүү өгөөж бүхий хөрөнгийн хувьд хүүгийн эрсдэлийн хувиуд ялгаатай байхаар зохицуулсан.

3

Дотоодын банк, банкнаас бусад санхүүгийн байгууллагын Зээлийн эрсдэлийг зээлжих зэрэглэлээс хамааран тооцоолох зохицуулалт:

Зээлийн эрсдэлийг дотоодын банк санхүүгийн байгууллага, үнэт цаас гаргагч, үнэт цаасны төрөл, авлагын чанар, давхар даатгагч, даатгалын зуучлагч, төлөөлөгч болон гадаадын банк, санхүүгийн

байгууллага, үнэт цаас гаргагч эсэхээр даатгагчийн харилцагч этгээдийг ялган, тэдгээрийн эрсдэлийн хувийг тогтоохдоо Дэлхийн банкны зөвлөх, олон улсын туршлага болон Даатгалын багц дүрэмд заасан төлбөрийн чадвар тооцох аргачлалд тусгагдсан зээлийн буюу хөрвөх чадварын эрсдэлийн хувиудыг ашигласан. Уг аргачлалд даатгагчид болон дотоодын банк, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын олон улсын болон дотоодын зээлжих зэрэглэлээс хамааран тэдгээрийн зээлийн эрсдэлийн хувь тогтоогддог байхаар өөрчлөлтийг оруулсан.

4

Андеррайтингийн эрсдэл – Мал амьтдын даатгалын эрсдэл – МИД ялгаатай тооцоолол:

Ердийн даатгалын андеррайтенгийн эрсдэлийн тооцооллыг даатгалын хэлбэр тус бүрийн хувьд хураамжийн эрсдэл болон нөхөн төлбөрийн эрсдэл гэж 2 тусад нь салгаж тооцдог. Харин Малын индексжүүлсэн даатгал нь бусад мал амьтадын даатгалтай харьцуулахад даатгагчийн хувьд харьцангуй бага эрсдэлтэй тул даатгалын компаниудын санал, тооцооллыг авч, МИД-ыг тусад нь ялгаж, эрсдэлийн хувийг тооцоолон, журамд тусгасан.

5

Амьдралын даатгалын андеррайтингийн эрсдэлийн тооцоолол:

Амьдралын даатгалын андеррайтингийн эрсдэл нь нас баралтын, насжилтын, гэрээ цуцлалтын, зардлын болон гамшгийн гэсэн 5 эрсдэлээс бүрддэг. Урт хугацааны даатгагчийн санал болон амьдралын даатгалын онцлогийг харгалзан үзэж, эдгээр

эрсдэлийг тооцоолох аргачлалыг даатгагч өөрөө боловсруулан, тооцоолох боломжийг журамд тусгасан. Мөн даатгагчийн үйл ажиллагааны онцлог, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын бодлогод нийцүүлэн, тодорхой судалгаа шинжилгээнд үндэслэн уг аргачлалыг боловсруулах талаар өөрчлөлт оруулсан.

6

Нэмэлт тайлантай холбогдох зохицуулалт

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 558 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан журмын дагуу Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолоход тус журмын хавсралтаар батлагдсан 14 маягтуудаас гадна нарийвчилсан мэдээлэл авч, тооцоолол хийх зориулалт бүхий 11 нэмэлт маягтуудыг боловсруулан, ердийн даатгалын компанийн хувьд нийт 22 маягтын дагуу, урт хугацааны даатгалын компанийн хувьд нийт 21 маягтын дагуу, давхар даатгагчийн хувьд нийт 25 маягтын дагуу тайлан мэдээллийг авч зайны хяналтыг хэрэгжүүлсэн. Хүүгийн эрсдэлийг хөрөнгө, өр төлбөрийн хугацааны зөрүүнд үндэслэн тооцохдоо холбогдуулан 2 тайлангийн маягт нэмэгдүүлж, Даатгалын багц дүрмийн хавсралт 11–т" тайлангийн маягтуудад сайжруулалт хийгдсэж "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан мэдээ, өргөдөл гаргах заавар"–т өөрчлөлт оруулснаар журмын хавсралт маягт 15, нэмэлт тайлангийн маягтын тоо 12 болж, ердийн даатгагчийн хувьд нийт 24, урт хугацааны даатгагчийн хувьд 25, давхар даатгагчийн хувьд нийт 27 маягтын хүрээнд тайлан мэдээлэл ирүүлэхээр тус тус тусгасан.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

АГААРЫН БОХИРДОЛ

Улаанбаатар хот хамгийн хүйтэн хотуудын гуравдугаарт, харин агаарын бохирдлын түвшнээр 27 дугаарт жагсаж байна. Өмнө нь жагсаж байгаа 26 хот магадгүй өөр шалтгаанаар агаарын бохирдолтой байх. Хотын маань агаарын бохирдлын 80 хувь нь айлуудын түлж буй түлшний утаанаас ялгардаг.

Хятадын Бээжин хот манай улстай адил туршлагатай нүүр тулж 20 жилийн тууштай бодлогын үр дүнд утаагүй хот болж чаджээ. Хүн амын шилжих хөдөлгөөн Бээжинд их төвлөрсөнтэй холбоотой гэр хорооллын нүүрс түлэх тоо огцом нэмэгдэж агаарын бохирдол өнөөдрийн манай байгаа түвшинд хүрчээ.

Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөл түүнийг даган гарах зардал, цаг хугацаатай холбоотой “Улаанбаатар хотын агаарын бохирдлоос үүдэлтэй ажил таслалтаас хувийн хэвшилд үүссэн зардлын судалгаа”-г 2020 оны 5 дугаар сард Зайгал судалгааны институт хийсэн. Судалгаанаас дараах үр дүн гарчээ. Үүнд:

“Агаарын бохирдлын улмаас Улаанбаатар хотын хүн амын дунд ханиалгах эрсдэл 1.46 сая, зүрх судасны өвчин 999.6 мянга, тархи судасны өвчин 1,487.5 мянга, амьсгалын замын өвчлөл 1,581.2 мянга, цочмог бронхит 33,823.6 мянга, астмын сэдэрл 41,384.6 мянга, архаг бронхит 11,372.6 мянган тохиолдол илэрсэн ба уг тоо жил тутам өссөөр байна.

Судалгаанд оролцсон байгууллагуудын дунд сүүлийн таван жилд ажил таслалттай холбоотой зардал ойролцоогоор 7.5 сая ам.доллар байв. Үүнээс Монгол Улсын эдийн засагт үүсэж байгаа агаарын бохирдолтой холбоотой алдагдсан боломжийн зардал 1.4 сая ам.доллар юм. Ажилтнуудад чиглэсэн уян хатан бодлого, төлөвлөлтгүй байгууллагуудад ажил таслалт өндөр байгаа бөгөөд ажил орлон гүйцэтгэгч хайх нь компанийн шууд бус зардлыг нэмэгдүүлж байна. Гаднаас орлон гүйцэтгэх ажилтан, ялангуяа тусгай лиценз эзэмшдэг мэргэжилтэн олох нь байгууллагын хувьд бэрхшээлтэй байна.”

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагын ажилтан өвлийн улиралд агаарын бохирдлоос шалтгаалсан өвчний улмаас 875.0 мянган төгрөгийн зардал гаргадаг байна. Уг зардалд гурван удаагийн оношилгоо, эмчид үзүүлэхтэй холбоотой зардал (нэг удаад дунджаар 65.0 мянган төгрөг), дөрвөн удаа эм худалдан авсан зардал (нэг



удаад дунджаар 70.0 мянган төгрөг), нэг удаа эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх зардал 200.0 мянган төгрөг багтаж байна. Эрүүл мэндтэй холбоогүй шууд бус зардал (унааны зардал) дөрвөн удаагийн давтамжтайгаар нийт 200.0 мянган төгрөг гаргадаг байна. Ажилтны шууд бус зардалд дунджаар гурван өдөр ажил тасалсны улмаас 120.0 мянган төгрөгийн цалингийн орлого алддаг байна.

Агаарын бохирдлыг бууруулах нь урт хугацааны бодлогын ажил хийгдсэний дараа үр дүн нь гардаг хэдий ч бид өөрсдийн эрүүл мэндийн төлөө, мөн өндөр алдагдсан боломжийн зардлыг хэмнэхийн тулд өөрөөсөө өөрчлөлтийг хийх цаг нэгэнт иржээ.

Агаарын бохирдлыг бууруулахгүй нөхцөлд гарах алдагдсан боломжийн зардлыг өрх гэрүүдийн яндангаас татгалзаж байшингаа дулаалан, цахилгаан халаагуур хэрэглэх зардалтай харьцуулбал:

Байшингаа дулаалаагүй нөхцөлд

Д/д	Зардлын төрөл	Хэмжээ /мянган төгрөг/
1	Түлшний зардал /зөвхөн хүйтний улиралд/	916.5
2	Эрүүл мэндийн зардал	875.0
3	Ажлаас чөлөө авснаар буурах цалингийн орлого	120.0
Нийт зардал /хүйтний улиралд/		1,911.5

Байшингаа дулаалаад, цахилгаан халаагуур хэрэглэх нөхцөлд нэг удаад 8,980.9 мянган төгрөгийн зардал гарах тооцооллыг өмнөх дугаараар хүргүүлсэн. Сүүлийн үед манай улс эрчим хүчийг шөнө хэрэглэдэг халаагуурыг өөрсдөө хийж, мөн гаднаас импортлох болсон. Уг халаагуурын хамгийн хүйтэн сард гарах зардлыг 130.0 мянган төгрөг гэж тооцсон.

10–20 жил ашиглах нэг удаагийн дулаалга болон халаагуурын зардлыг 5 жилд нөхөхөөр харагдаж байгаа ч нэг өрх эрүүл мэнд, түлшний зардлаа 5 жилээр хэмнэж байгаа юм.

Мөнгөн зардлаас гадна дулаан байшинд халаагуур ашиглаад үүсэх үр өгөөж, давуу талууд мөн бий. Үүнд:

- ◆ Тав тухтай орчин;
- ◆ Дуртай зүйлдээ зарцуулах цаг хугацаа илүү гарна;
- ◆ Эрүүл биед саруул ухаан оршино;
- ◆ Аз жаргалын түвшин нэмэгдэнэ гэх мэт.

Гэхдээ та байшин дулаалах, халаагуур авах их хэмжээний мөнгөн хөрөнгө олоход бэрхшээлтэй гэж бодож байгаа бол үгүй юм. Та үүнийг хэд хэдэн аргаар олох боломжтой. Үүнд:

- ◆ Хуримтлал үүсгэх /өөртөө зуршил үүсгэх/;
- ◆ Ногоон зээл авах /бага хүүтэй/;
- ◆ Орлогоо нэмэгдүүлэх.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТУЗ-ИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ – ЧИГ ХАНДЛАГА 2024

Сүүлийн жилүүдэд компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гүйцэтгэсэн ажлыг үнэлэх үйл явц шинэчлэгдэж, асуулга бөглөх, судалгааны уламжлалт аргаас стратегийн арга барил руу шилжих хандлага ажиглагдаж байна. Энэхүү шилжилтээр ТУЗ-ийн ажлын гүйцэтгэл нь компанийн хувьд стратегийн чухал үнэ цэнэтэй зүйл болохыг нийтээр хүлээн зөвшөөрч буйг харуулж байна.

Чиг хандлага

ТУЗ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээнд дараах хэд хэдэн чиг хандлага зонхилж байна. Үүнд:

Нэгдүгээрт, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагааны гүйцэтгэлд тавих хяналт нэмэгдэж, нас, хүйс, арьс өнгө, үндэстний цөөнх зэрэг компанийн үйл ажиллагаанд хангалттай хэмжээнд төлөөлөл болж чаддаггүй зорилтот бүлгүүдэд анхаарал хандуулж байна.

Хоёрдугаарт, хүний нөөцийн менежмент болон эрх тэгш, олон талт оролцоог хангахыг тэргүүн ээлжид анхаарч байна. Эцэст нь засаглалын үйл явцын автоматжуулалт нь ТУЗ-ийн өрсөлдөх чадвар, бүтэц бүрэлдэхүүнд чухал нөлөө үзүүлнэ.

Эдийн засгийн тодорхойгүй байдал, инфляцын өсөлтийн үр дүнд компаниудын ТУЗ-үүд стратегийн гүйцэтгэлийн үр дүн болоод гадаад нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөгөө өөрчлөх шаардлага 2024 онд эрчимжих, зэрэгцээд ТУЗ-ийн бүрэлдэхүүний томилгооны хугацааг уртасгах болон шинэ гишүүдээр сэлгэлт хийх асуудлыг тэнцвэртэй хэрэгжүүлэх хандлагатай байна.

Ирээдүйг таамаглахад

Компанийн засаглал цаашид ч хөгжлийнхөө дараагийн шат руу хөдлөх нь дамжиггүй ба ТУЗ-үүд макро эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдалд тохирсон дотоод зохицуулалтуудыг хийх, мэдээлэл, тайлагналын ил тод байдал болон үүрэг, хариуцлага нэмэгдүүлэх зэрэг сорилтуудтай тулгарч, тэдгээрт бэлэн байх шаардлагатай болно.

БОНЗ

Байгаль Орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын хүчин зүйлс нь компанийн засаглалын хувьд улам бүр чухал болж, зөвхөн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад төдийгүй, ТУЗ-ийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд нөлөөлж эхлэв.

Энэ нь хүрээлэн буй орчны асуудал, нийгмийн хариуцлагаас эхлээд засаглалын бүтэц, үйл ажиллагаа хүртэл өргөн хүрээний асуудлыг хамардаг. Эдгээр хүчин зүйлсийг компанийн урт хугацааны тогтвортой байдал, ёс зүйн чухал үзүүлэлтүүд гэж үздэг болов.

ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээнд БОНЗ-ын хүчин зүйлсийг харгалзан үзэх нь хэд хэдэн үр дагавартай байдаг. Үүнд:

Нэгдүгээрт, гүйцэтгэлийн үнэлгээний цар хүрээнд санхүүгийн уламжлалт хэмжүүрээс гадна, хүрээлэн орчинд үзүүлэх үр нөлөө, нийгмийн хариуцлага, засаглалын үйл ажиллагаа зэрэг санхүүгийн бус гүйцэтгэлийн үзүүлэлтийг багтаадаг бөгөөд ийнхүү өргөн хүрээнд авч үзэх нь БОНЗ-ын гүйцэтгэл компанийн урт хугацааны амжилттай нягт холбоотой гэдгийг харуулна.

Хоёрдугаарт, БОНЗ-ын хүчин зүйлс болох хүйсийн тэнцвэртэй байдал, нийгмийн гарал, мэргэшлийн хувьд олон талт байдлыг засаглалын тогтолцоонд нэвтрүүлэх шаардлага нэмэгдсэнээр ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд шууд нөлөөлнө. Тэрээр эцсийн дүндээ ТУЗ-ийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад нөлөөлж, компанийн БОНЗ-ын бодлого, төлөвлөлт, гүйцэтгэлд ТУЗ хяналт тавих төлөвтэй байна.

БОНЗ-ын хүчин зүйлс нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөрөнгө оруулагчид БОНЗ-ын гүйцэтгэл сайтай компанид илүү ач холбогдол өгч, хөрөнгө оруулалт хийх сонирхол ажиглагдаж байна.

Энэ хандлага нь БОНЗ-ын хүчин зүйлс компанийн санхүүгийн гүйцэтгэл болон эрсдэлийн төлөв байдалд нөлөөлнө гэдгийг хүлээн зөвшөөрч буйг харуулж байна. Тухайлбал, хүрээлэн орчны чиглэлээр сайн туршлага бүхий компаниуд байгаль орчны асуудалтай холбоотой хууль тогтоомжийн өөрчлөлтийн болон нэр хүндийн эрсдэлийг хөнгөхөн даван туулах чадвартай байж болно.

Үүний нэгэн адил, хүчирхэг засаглалтай, туршлагатай компаниуд нэр хүнд ба санхүүгийн үйл ажиллагаанд нь асар их хохирол үзүүлэх магадлал бүхий компанийн засаглалтай холбоотой эрсдэлээс зайлсхийх магадлал өндөр байдаг.

Ойрын ирээдүйд ТУЗ-ийн үнэлгээнд БОНЗ-ын хүчин зүйлсийн ач холбогдол улам бүр нэмэгдэх хандлага гарч байна. ТУЗ нь БОНЗ-ын асуудлуудын талаар сайн мэдлэг, мэдээлэлтэй байхаас гадна, өөрийн гаргаж буй стратегийн шийдвэрийг тэдгээртэй уялдуулах чадвартай байх хэрэгтэй. Үүнээс улбаалан, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинэ ур чадвар, дадлагыг хөгжүүлэх, БОНЗ-д тавих хяналтыг илүү чанга, илүү ил тод болгохыг шаардана.

Хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд БОНЗ-ын асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж чаддаг ТУЗ нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангах тал дээр илүү боломжтой байна.

Эрсдэлийг нэгтгэх

БОНЗ-ын эрсдэлийг ойрын хугацаанд өөрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэгтгэх нь эрсдэлийг

бууруулах чухал алхам болно. Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн тэгш бус байдал, бизнесийн ёс зүйн хэм хэмжээ зэрэг БОНЗ-ын хүчин зүйлс нь компанийн урт хугацааны тогтвортой хөгжил, санхүүгийн гүйцэтгэлд ихээхэн нөлөөлдөг. БОНЗ-ын эрсдэлийг байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэгтгэснээр шийдвэр гаргах үйл явц, оролцогч талуудын харилцааг сайжруулах, мөн нэр хүнд болон үйл ажиллагааны эрсдэлээ бууруулах боломжтой.

БОНЗ-ын эрсдэлийг үр дүнтэй нэгтгэхийн тулд байгууллагынхаа онцлог эрсдэлд тохирсон БОНЗ-ын стратегийг боловсруулах шаардлагатай. Иймд байгууллагын үйл ажиллагаа, ханган нийлүүлэлтийн сүлжээ, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлага, хүлээлт зэрэгт иж бүрэн үнэлгээ хийж, БОНЗ-ын бодит эрсдлээ тогтоох нь зүйтэй. БОНЗ-ын эрсдэлийг байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэгтгэхэд ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын оролцоо, хяналт нь маш чухал. Учир нь хэрэгжүүлэх, хянах чиг үүрэг, хариуцлагыг маш тодорхой тогтоох, БОНЗ-ын зорилт, гүйцэтгэлийг тодорхойлон цалин урамшууллын шалгуурыг тусгах нь энэхүү интеграцийг улам хүчтэй болгох аж.



ФИНТЕК БА РЕГТЕК

ДЭЛХИЙН ФИНТЕКИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2028 ОН ХҮРТЭЛХ ОРЛОГО

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ дэлхийн финтекийн зах зээлийн 2028 он хүртэлх орлогын мэдээлэл болон таамаглалыг хүргэхээр бэлтгэлээ.

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага болох McKinsey-ээс 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр гаргасан сэтгүүлийн дугаарт 2023 оны 7 дугаар сарын байдлаар олон нийтэд арилжаалагддаг финтекүүдийн зах зээлийн үнэлгээ 550.0 тэрбум ам.доллар байна. Энэ нь 2019 онтой харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлт юм. Нэмж дурдахад, мөн үеийн байдлаар 272 гаруй финтекийн юникорн компаниуд байгаа бөгөөд нийт үнэлгээ нь 936.0 тэрбум ам.долларт хүрсэн байна.


Сүүлийн 10 жилийн хугацаанд технологийн дэвшил, инновац нь финтекийн салбарыг захаас санхүүгийн үйлчилгээний тэргүүн эгнээнд аваачсан. Банкны салбарын эрчимтэй өсөлт, хурдацтай дижиталчлал, үйлчлүүлэгчдийн сонголт өөрчлөгдөж, хөрөнгө оруулагчид болон зохицуулагчдын дэмжлэг нэмэгдсэн зэрэг нь өсөлтийг хурдацтай өсгөсөн. Энэ хугацаанд финтекүүд шинэлэг, ялгаатай, хэрэглэгчдэд чиглэсэн үнэ цэнтэй саналууд, хамтын ажиллагааны бизнесийн загварууд, олон ур чадвартай, уян хатан

багуудаараа санхүүгийн үйлчилгээний тодорхой чиглэлүүдийг гүн гүнзгий өөрчилжээ.

2022 онд зах зээлийн бууруулах хүчин зүйлүүд нь энэхүү тэсрэх өсөлтийн эрчийг удаашруулахад хүргэсэн. Санхүүжилтийн үйл ажиллагаа, хэлцлийн тоо нийтдээ буурч, IPO болон SPAC (тусгай зориулалтын худалдан авалтын компани)-ын жагсаалт цөөрч, түүнчлэн шинэ юникорн бий болох нь буурсан. Макро орчин нь бас хэцүү, тодорхойгүй хэвээр байна. Шинэ эринд санхүүжилтийн орчин хүндрэлтэй байгаа нь финтекүүд спринт хийх боломжгүй болсон гэсэн үг. Өрсөлдөх чадвартай хэвээр үлдэхийн тулд илүү удаан, тогтвортой хурдаар өсөх хэрэгтэй болж байна.


Банкны салбар 2022 онд 6.5 их наяд гаруй ам.долларын орлого олсон. 2022 онд финтекүүд дэлхийн банкны салбарын цэвэр орлогын 5 хувийг (буюу 150–205 тэрбум ам. доллар) эзэлж байна. McKinsey тооцооллоор энэ хувь хэмжээ 2028 он гэхэд 400.0 тэрбум ам.долларт хүрч өсөх бөгөөд энэ нь 2022–2028 оны хооронд финтекийн орлогын жилийн 15 хувийн өсөлттэй байгаа нь банкны салбарын 6 хувийн өсөлтөөс гурав дахин их юм.

Fintech net revenues by region,¹ \$ billion



Эх сурвалж: McKinsey

Global fintech revenue share by region, level of development, %



¹Net revenue is defined as revenue after risk minus direct costs,

²Latin America, Africa, Middle East, and Asia, excluding China.

Source: Dealroom.co; McKinsey analysis

McKinsey & Company

Эх сурвалж: McKinsey

Хөгжиж буй зах зээлүүд энэ орлогын өсөлтийн ихэнх хэсгийг хангах болно. Африк, Ази-Номхон далай (Хятадаас бусад), Латин Америк, Ойрх Дорнод дахь финтекийн орлого нь өнгөрсөн онд финтекийн дэлхийн нийт орлогын 15 хувийг эзэлжээ. McKinsey

тооцоолсноор 2028 он гэхэд нийтдээ 29 хувь хүртэл өснө. Нөгөөтээгүүр, одоогийн байдлаар дэлхийн финтекийн орлогын 48 хувийг бүрдүүлж буй Хойд Америк 2028 он гэхэд 41 хувь болж буурах төлөвтэй байна.



СУДЛААЧИЙН ИНДЭР

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, газрын ахлах мэргэжилтэн
С:Будбаяр budbayar@frc.mn

ХУРААНГУЙ

Санхүүгийн хямрал нь хяналтын тогтолцооны алдааг ил болгож, цаашид санхүүгийн салбарыг зохицуулах шаардлагатайг харуулсан. Системийн хувьд ач холбогдол бүхий байгууллагуудын хяналт, зохицуулалтын аргачлалыг өөрчлөх шаардлага үүсээд байна.

Энэхүү судалгаагаар Монгол Улсын даатгалын зах зээлийн системийн хэмжээнд үзүүлэх эрсдэлийн нөлөөг эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалаар тооцон үнэлэхийг зорьсон.

Судалгаанд 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацаан цуваа тоон мэдээллийг 7 бүлгийн 41 үзүүлэлтээр тооцооллоо. Үүний тулд үзүүлэлт тус бүрийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож, түүнээс давсан нөхцөлд системийн эрсдэл, хямрал тохиолдоно гэсэн таамаглал дэвшүүлсэн.

Системийн эрсдэл тохиолдох эсэх магадлалыг 2017 онд тохиолдсон санхүүгийн мөчлөгийн ёроол цэгийг жишиг болгосон ба хямрал тохиолдсон үеийн дараагийн улиралд буюу 2018 оны 1 дүгээр улиралд ихэнх үзүүлэлт нь шар, улаан болсон нь хямралын нөлөөлөл бий болсныг илтгэж байна. Мөн дэлхий нийтээр эдийн засаг тогтворгүй болсон Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үе /2020 оны 1 дүгээр улирал/ болон дараагийн улирлуудад ихэнх үзүүлэлтэд хямралын нөлөөлөл ажиглагдсан болно

УДИРТГАЛ

Даатгалын компаниуд нь санхүүгийн болон эдийн засгийн эрсдэлээс хамгаалах үйлчилгээ үзүүлэгчийн хувьд эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүүлийн жилүүдэд даатгалын компаниудын системийн эрсдэлд үзүүлэх нөлөө нэмэгдсэн.

Олон улсын валютын сангийн тайланд дурдсанаар энэхүү өсөлт нь үндсэн 2 шалтгаанаас үүдэлтэй байна. Нэгдүгээрт, даатгагчдын зээлийн хүүгийн мэдрэмж нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, нийт эрсдэлд өртөх магадлал нэмэгдсэн. Хоёрдугаарт, цахим даатгалын эрсдэл нэмэгдсэн. Дэлхийн санхүүгийн системийн холбоо хамааралтай уялдуулан дэвшилтэт технологид илүү их найдах, кибер аюул заналхийлэл нь системийн шинж чанартай болж байна гэсэн үг юм.

Санхүүгийн байгууллагууд хоорондын холбоо хамаарал, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг зохицуулаагүйн улмаас үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлт хагарснаас үүдэн дэлхий нийтийг хамарсан 2008–2009 оны санхүүгийн хямралын дараа системийн эрсдэлийг хязгаарлах зорилгоор зарим зохицуулагч байгууллагууд макро зохистой бодлого хэрэгжүүлэхийг дэмжсэн. Ялангуяа даатгалын зах зээлд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /FSB/ нь дэлхийн системийн нөлөө бүхий даатгагчдын жагсаалтыг гаргасан бөгөөд эдгээр байгууллагуудад зориулсан тусгай бодлогын арга хэмжээг 2019 оноос хэрэгжүүлж байна. Макро–зохистой бодлогыг эхлүүлэх оролдлогыг үл харгалзан ихэнх даатгалын зохицуулалт нь микро–зохистой шинж чанартай хэвээр байна.

Энэхүү судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн талаар болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан системийн эрсдэлийг үнэлэх хэмжигдэхүүнийг, хоёрдугаар бүлэгт эрт илрүүлэх дохиоллын системийн арга зүй болон даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг тодорхойлсон бол гуравдугаар бүлэгт даатгалын зах зээлийн 2022 оны нөхцөл байдлыг тодорхойлсон. Дөрөвдүгээр бүлэгт дээрх аргачлалыг ашиглан даатгалын зах зээлийн 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацаан цуваа тоон мэдээллийг 7 бүлгийн 40 үзүүлэлтээр тооцоолол хийж, санал дүгнэлт хэсгээр судалгаагаа дүгнэсэн болно.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛ

Санхүүгийн хямралын үед банк болон даатгагчид өөр өөр үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд хямралын эх үүсвэр болсон банкуудад илүү хүндээр нөлөөлсөн.

Санхүүгийн хямралаас хойш олон улсын бодлого боловсруулагчид системийн эрсдэлтэй тэмцэх зохицуулалтын тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Тэд хамгийн анх банкны салбарыг судалж байсан бол дараагаар нь даатгалын зах зээлийг судалж эхэлсэн. Дэлхийн системийн ач холбогдол бүхий даатгагчдыг

тодорхойлох аргачлалыг боловсруулах, тэдгээрийн нөлөөг бууруулах бодлогын арга хэмжээ боловсруулахыг Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбооноос үүрэг болгосон байна.

Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо /IAIS/ нь 2015 оны байдлаар системийн нөлөө бүхий даатгагчдыг зарласан ба 2018 оноос эхлэн тус холбоо болон үндэсний эрх баригчид зөвшилцөн энэхүү жагсаалтыг цаашид нийтлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

Зураг. Системийн нөлөө бүхий даатгалын компаниуд /2015 оны байдлаар/



Хямралын үед даатгагчид үйл ажиллагаа, бизнесийн хэмжээ, үнийг харьцангуй тогтвортой барьсан ч Америкийн олон улсын групп /AIG/ болон хэд хэдэн даатгагчдад ихээхэн хүндрэл бэрхшээл тулгарч, үйл ажиллагаа нь унасан.

Даатгуулагчид эрсдэлээ даатгуулж, хураамж төлдөг учраас даатгалын компаниудаас их санхүүжилт шаардагдахгүйгээр үйл ажиллагаа явагддаг. Даатгагч болон давхар даатгагч нь санхүүгийн системийн тогтвортой байдлын эх үүсвэр болдог

онцлог шинж чанартай. Даатгалын бодлого нь ерөнхийдөө урт хугацаатай бөгөөд даатгуулагчдад санхүүгийн системийн тогтворжуулагч болж ажиллах боломжийг олгодог.

Европын Даатгал, Мэргэжлийн Тэтгэврийн газар /EIOPA/-ын тодорхойлсон системийн эрсдэлийг арилгах алхам болон даатгалын зах зээлийн системийн эрсдэл үүсэх шалтгаан нь дараах байдалтай байна.

Зураг. Системийн эрсдэлийг арилгах алхам




1. Хөрвөх чадварын эрсдэл, макро эдийн засгийн эрсдэл гэсэн 2 чиглэлд илүүтэй анхаардаг.
2. Шинэ бодлогын арга хэмжээ авах хэрэгцээ/шаардлагыг тодорхойлох
3. Системийн эрсдэлд шинжилгээ хийх – Бодлогын аль нэг арга хэмжээгээр хангалттай бууруулж чадаагүй эрсдэлийг тодорхойлох
4. Системийн бүх үлдэгдлийг арилгах

Хүснэгт 1. Системийн эрсдэл үүсэх шалтгаан

Системийн эрсдэл үүсэх шалтгаан	Зөвлөмж
Байгууллагад суурилсан – шууд үйл ажиллагаанд суурилсан	<ul style="list-style-type: none"> • Алдагдлыг нөхөх нөөц бололцоог хангалттай байлгах • Тодорхой үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүнд хэт их анхаарал хандуулахгүй байх /тэнцвэртэй байдлыг хадгалах/ • Мөчлөгийн эрсдэлээс болгоомжлох • Эрсдэлтэй үйл ажиллагаа хийхээс өмнө судлах
Төлбөрийн чадвар муудаж, даатгалын эрсдэл тохиолдох	
Үйл ажиллагаанд суурилсан – шууд бус үйл ажиллагаанд суурилсан	
Тодорхой үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүнээс болж системийн эрсдэл үүсэх	
Зан төлөвт суурилсан – шууд бус үйл ажиллагаанд суурилсан	
<ul style="list-style-type: none"> • Даатгалын компани хэт их эрсдэл хүлээх • Өр төлбөрийн эрсдэл үүсэх 	

IAIS–н Дэлхийн хяналтын газар нь /GME/ нь дэлхийн даатгалын зах зээл дэх эрсдэл, чиг хандлагыг тодорхойлох, системийн эрсдэл үүсэх нөхцөл байдлыг үнэлдэг. Хяналт, зохицуулалтын байгууллагууд дэлхийн хэмжээнд өнөөгийн даатгалын зах зээлийн эрсдэлд хяналт тавих, тандалт судалгааг төрөлжүүлэх, тус зах зээлийн системийн эрсдэлийг тодорхойлох мониторинг, шинжилгээг нэмэгдүүлэхийн тулд цаашид интервенц хийхээр төлөвлөж байна.

Зураг. Дэлхийн банкны салбар болон даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн оноожуулалт




Даатгагчдын системийн эрсдэлийн нийт оноолт нь банкны салбараас хамаагүй бага хэвээр байна. Системийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн хамгийн их эрсдэлтэй нь хөрвөх чадваргүй активууд, санхүүгийн дотоод хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, дериватив болон санхүүгийн дотоод өр төлбөрийн үзүүлэлтүүд байна.

Ерөнхийдөө даатгалын зах зээлийн системийн эрсдэл дунд түвшинд хэвээр байгаа боловч хөрвөх чадваргүй, үнэлэгдэхэд хэцүү хөрөнгө, биржээс гадуурх дериватив, богино хугацаат эх үүсвэр, санхүүгийн дотоод хөрөнгийн эрсдэл зэрэг нь нэмэгдэж байгаагаас хамааран цаашид тус зах зээлийн системийн эрсдэл өсөх хандлагатай байна.

2021 онд дэлхийн даатгагчдын төлбөрийн чадвар болон ашигт ажиллагааны үзүүлэлт сайжирч, санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь нэмэгдсэн. Харин 2022 онд геополитикийн зөрчилдөөн, инфляц, мөнгөний хатуу бодлого, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг хүчин зүйлсээс хамааран хөрвөх чадварын эрсдэл нэмэгдсэн.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /FSB/ нь хэмжээ, холбоо хамаарал, хөрвөх чадвар гэсэн 3 шалгуураар системийн эрсдэлийг үнэлдэг байсан бол Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо /IAIS/ нь цаг хугацаа буюу алдагдлыг гуравдагч этгээдэд дамжуулах хурдыг дөрөв дэх шалгуур болгон нэмсэн.

Зураг. Системийн эрсдэлийн 4 шалгуур



Даатгагч, давхар даатгалын үндсэн үйл ажиллагаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гурван шалгуурыг ашигласнаар системчилсэн эрсдэлд орох магадлал бага гэж дүгнэдэг. Эдгээр үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтын менежмент (хөрөнгө оруулалтын бодлого, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө), хариуцлагын эх үүсвэр (хамгаалалт, баталгаа өгөх), эрсдэл шилжүүлэх (давхар даатгал, үнэт цаасжуулах гэх мэт), хөрөнгийн менежмент орно. Европын Холбооны Solvency II даатгалын зохицуулалт нь даатгалын үйл ажиллагааг зохих ёсоор хангаж өгдөг. Харин эдгээр зохицуулалт нь үндсэн бус үйл ажиллагаанаас үүдэлтэй системийн болзошгүй эрсдэлийг зохих ёсоор бууруулж чадаж байна уу, эсхүл шинэ арга хэмжээ авах, солих шаардлагатай байна уу гэдгийг анхаарах шаардлагатай.

Даатгагчийн үндсэн үүрэг болох даатгалын чиг үүрэг нь даатгуулагчдын эрсдэлийг хүлээн авах, эдгээр эрсдэлийг нэгтгэх, идэвхтэй удирдах, давхар даатгагчид хэсэгчлэн шилжүүлэх замаар хамгаалах үйлчилгээ юм.

Даатгал нь эрсдэлийн санхүүгийн үр дагаврыг нэгтгэх, шилжүүлэх механизмыг бий болгодог. Даатгуулагч шимтгэлийн хариуд гэрээ, үйл ажиллагааны зардал, хөрөнгийн зардлаас үүдэлтэй хүлээгдэж буй алдагдлыг даатгуулагчид санхүүгийн хувьд нөхөн төлөх үүрэг хүлээдэг.

Даатгагчид эрсдэл хүлээж байгаа тул эдгээр эрсдэлийг удирдах, ялангуяа даатгагчид шилжүүлэх зэрэгт онцгой анхаарал хандуулдаг. Даатгагчид даатгуулагчдад эрсдэлээ өөрсдөө удирдах, бууруулахад нь ихээхэн хөрөнгө оруулалт хийдэг. Даатгагчдын хүлээх эрсдэл нь олон янз байдаг бөгөөд даатгагчид эдийн засгийн бусад оролцогчдод учирч болзошгүй зарим эрсдэлийг даатгуулах боломжтой гэж үзэж болох шинэ чиглэлүүдийг байнга хайж байдаг.

Банкны үйл ажиллагааны системийн эрсдэл, хөрөнгийн зах зээлийн системийн эрсдэл болон даатгалын зах зээлийн эрсдэл зэрэг нь харилцан адилгүй байдаг бөгөөд нөлөөлж буй хүчин зүйлс, үр дүн нь өөр өөр байдаг. Даатгалын эрсдэл нь өвөрмөц шинж чанартай бөгөөд ихэнх тохиолдолд эдийн засгийн мөчлөгөөс хамаардаггүй. Богино хугацаат, хөрвөх чадвартай хугацаат хадгаламжийг хүлээн авч, урт хугацаат зээл олгосноор банкнууд зээлийн үйл ажиллагаатай холбоотой зээлийн эрсдэл, богино хугацаат зээлээс үүссэн үл нийцэх байдлаас үүдэн хөрвөх чадварын эрсдэлийг хариуцдаг.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь зарим байгууллагын эмзэг байдлыг нэмэгдүүлж болзошгүй хоёрдогч шалгуурыг тодорхойлсон. Үүнд:

Зураг. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн тодорхойлсон хоёрдогч шалгуур



Хэмжээ

Системийн эрсдэлийн хувьд тухайн байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны бүтэц, харилцан хамаарал гэх мэт хүчин зүйлс нь чухал нөлөөтэй байдаг.

Холбоо хамаарал

Холбоо хамаарал нь системийн эрсдэлийн чухал хэмжигдэхүүн юм. Санхүүгийн байгууллагуудын хоорондын харилцан үйлчлэл нь өмчлөлийн хэлбэр, төлбөрийн систем, эрсдэлийн үйл ажиллагаа, давхар даатгал зэргээс хамааран харилцан адилгүй хэлбэртэй байдаг.

Хөрвөх чадвар

Байгууллагын санхүүгийн үйлчилгээний хөрвөх чадварыг тодорхойлоход дараах 2 хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

- ◆ Тухайн байгууллагын зах зээлд эзлэх байр суурь, байгууллага дампуурахад түүнийг орлох байгууллага богино хугацаанд бий болох боломжтой эсэх;
- ◆ Тухайн байгууллагын зах зээлд нэвтрүүлж буй үйлчилгээ нөлөө бүхий эсэх.

Хугацаа

Даатгалын нөхөн төлбөр нь банкны нэхэмжлэлтэй харьцуулахад харьцангуй хурдан хугацаанд шийдвэрлэгддэг. Тухайлбал, Дэлхийн худалдааны төвтэй холбоотой нэхэмжлэлийн 50 гаруй хувь нь 2 жил орчмын дараа шийдвэрлэгдсэн байдалтай байна.

Ихэвчлэн нэхэмжлэлийн агуулга, шүүхийн шийдвэр, нэхэмжлэгч зэргээс хамааран өөр өөр хугацаатай шийдвэрлэгддэг.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Системийн эрсдэлийг тодорхойлох, хэмжихэд чиглэсэн олон арга зүй, эмпирик судалгаа байдаг ч даатгалын зах зээлд 100 хувь тохирсон аргачлал одоогоор байхгүй. Судлаачид даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг дараах байдлаар тодорхойлсон:

1. Камминс ба Вайсс, Харрингтон, Тайлер, Хорниг, Грейс: Уламжлалт даатгалын үйл ажиллагаа нь системийн эрсдэл үүсгэдэггүй.
2. Ричардсон, Бобчэф: Уламжлалт даатгалын үйл ажиллагаа нь эрсдэлийг төрөлжүүлэх замаар хийгддэг тул системийн эрсдэл үүсгэдэггүй. Гэвч энэ нь уламжлалт бус үйл ажиллагаанд хамаардаггүй.
3. Ачария: Статистик мэдээлэл, системийн эрсдэлийн хэмжүүр дээр үндэслэн уламжлалт бизнесийн загвартай даатгагчид уламжлалт бус даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудаас ялгаатай нь системийн эрсдэл бага.
4. Бах ба Нгуен: Бусад үйл ажиллагаа тухайлбал, кибер даатгалын андеррайтеринг хийх зэрэг эсхүл уламжлалт даатгалд гэрээний нэмэлт заалтуудыг хавсаргасан тохиолдолд системийн эрсдэл үүсэх хандлагатай байдаг. Хэдийгээр уламжлалт даатгалын үйл ажиллагаа нь системийн хувьд эрсдэлтэй биш ч гэсэн даатгалын зах зээлийн эдийн засгийн зардлаас шалтгаалан макро зохистой зохицуулалт хийх шаардлагатай.

5. Берри, Столэл: 2007–2009 оны хямралын үед даатгагчид мөнгө босгоход ямар ч бэрхшээлгүй байсан. Тиймээс даатгалын зах зээлд нэмэлт зохицуулалт шаардлагагүй.

Иймд энэхүү судалгааны ажлаар эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалыг ашиглан Монгол Улсын даатгалын зах зээлийн системийн хэмжээнд үзүүлэх эрсдэлийн нөлөөг тоохон үнэлэхийг зорилгоо.

Эрт илрүүлэх дохиоллын систем нь хугацааны цуваан үзүүлэлтийн дундаж болон стандарт хазайлтыг тооцоолон уг стандарт хазайлтын тодорхой түвшнээс тухайн улиралд давсан нөхцөлд системийн эрсдэл үүссэнийг таамагладаг аргачлал юм.

Одоогийн байдлаар даатгагчдын хяналт шалгалт, зохицуулалтын үйл явцыг хялбаршуулах системийн эрсдэлийн талаар судалгааны ажил ховор байна. Хөрөнгийн зах зээл, банкны салбарт эрт илрүүлэх дохиоллын системийн талаар нарийвчилсан ойлголт, эрсдэлийг үнэлэх, нийт эдийн засгийн тогтолцооны үйл явдлыг урьдчилан таамаглах талаар өргөн хүрээнд судалсан байдаг ч даатгалын зах зээлд чиглэсэн судалгаа төдийлөн хийгдээгүй байна.

Зураг. Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн судлагдсан байдал




ЭМПИРИК СУДАЛГАА

Даатгалын зах зээлд үүсэх системийн эрсдэлийг эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалыг ашиглан 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацаан цуваа тоон мэдээллийг 7 бүлгийн 40 үзүүлэлтэд шинжилгээ хийлээ. Үүний тулд үзүүлэлт тус бүрийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож, түүнээс давсан нөхцөлд системийн эрсдэл, хямрал тохиолдоно гэсэн таамаглал дэвшүүлсэн.

Монгол Улсын санхүүгийн мөчлөг

Санхүүгийн зах зээл дэх хямрал тохиолдох магадлалыг Монгол Улсад өмнө нь тохиолдож байсан 2017 оны мөчлөгийн уналт болон 2020–2021 оны Ковид–19 цар тахлыг жишиг болгон харлаа.

Зураг. Хямралтай болон хямралын дараах улирлын үзүүлэлтийн төлөв байдал



Дээрх 2 зурагт буюу 2018 оны 1 дүгээр улирал болон 2020 оны 1 дүгээр улирлын системийн эрсдэлийн зураглалыг харахад харгалзан улаан тэмдэглэгээтэй 7, 9 үзүүлэлт байсан ба энэ нь хямралын дохио илэрсэн болохыг илтгэнэ.

Хямралын өмнөх 1 улиралд улаан болон шар тэмдэглэгээ огцом нэмэгдсэн байгаа нь эрт илрүүлэх дохиоллын системийн аргыг ашигласнаар хямралыг 1 улирлын өмнө урьдчилан таамаглах боломжтойг харуулж байна.

2017 онд үүссэн хямралаас үүдэн 2018 оны 1 дүгээр улирлын санхүүгийн байдлын үнэлгээ, ашигт ажиллагааны үнэлгээ болон үйл ажиллагааны шинжилгээний бүлгийн үзүүлэлтүүд огцом өссөн үзүүлэлттэй гарсан. Энэ нь үзүүлэлтийг улаанаар тэмдэглэх хүчин зүйл болж, хямралын дохиог өгсөн байна.

Дээрх зургаас харахад, хямралын үеэр үзүүлэлтүүд далайцтай өөрчлөлтүүдийг үзүүлдэг бол 1–2 улирлын дараагаас хэвийн байдалдаа шилжиж байгааг харж байна.

Хугацааны цуваагаар тооцсон эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлал

Системийн эрсдэлийн зураглалаас 2019 оны 4 дүгээр улирал болон 2020 оны 1, 2 дугаар улирлын үзүүлэлтийг харахад санхүүгийн байдлын үнэлгээний бүлгийн үзүүлэлтээс бусад бүлгийн үзүүлэлтэд огцом өөрчлөлт гарсан байна. 2020 оны эхний хагас жилийн байдал нь Ковид–19–ийн цар тахлаас шууд хамааралтай байсан нь 2020 оны 1 дүгээр улирлын олон улаан, шар тэмдэглэгээтэй байна.

Хугацааны цуваагаар тооцсон эрт илрүүлэх дохиологч системийн арга нь системийн эрсдэлийг тооцоход Монгол Улсад санхүүгийн хямрал тохиолдсон 2016, 2020 онд сонгосон 40 үзүүлэлт хамгийн ихээр хямрал тохиосон гэж харуулсан. Учир нь 2017. IV–2018. II болон 2019. IV–2020. II улиралд 1.5 стандарт хазайлтаас /стандарт хазайлт*1.5/ их хэлбэлзэж хямрал тохиолдох өндөр магадлалтайг илэрхийлсэн нь дээрх хугацаанд тохиосон санхүүгийн хямралуудтай цаг хугацааны хувьд яг таарч байна.

ДҮГНЭЛТ

Эрт илрүүлэх дохиологч системийн Даатгалын компаниудын системийн эрсдэлийг таамаглах байдал нь Монгол Улсад санхүүгийн мөчлөгийн ёроол цэг тохиолдож байсан үетэй давхацсан тул уг аргачлалаар системийн эрсдэлийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Даатгалын зах зээлийн болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах зорилгоор эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалыг ашиглан 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацааны цуваан тоон мэдээллийг ашиглан 7 бүлгийн 40 үзүүлэлт үзүүлэлтэд тулгуурлан тооцоолол, шинжилгээ хийлээ.

Санхүүгийн хямрал тохиолдсон 2017.IV–2018.II болон 2019.IV–2020.II улиралд тус тус 24.5 ба 25.5 оноотой гарсан ба хямрал тохиолдсоны дараагийн 1–2 улиралд зах зээл нь эргэн хэвийн байдалдаа орж буй зураглал ажиглагдсан. Харин хямрал тохиолдохын өмнөх улиралд тооцоолсон 40 үзүүлэлтийн 4–8 үзүүлэлт улаан тэмдэглэгээтэй гарч, хямралын дохиоллыг анхааруулсан байв.

Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг улирал бүр эрт илрүүлэх дохиоллын аргачлалаар тооцоолох саналтай байгаа ба эрсдэлийн оноолтыг тухай бүр тодорхойлсноор хямрал тохиолдохоос 1 улирлын өмнө таамаглах боломжтой гэж харж байна. Зах зээлд тохиолдох эрсдэл/хямралыг 1 улирлын өмнө тодорхойлж чадсанаар бодлогын хэмжээнд арга хэмжээ авч, системийн хэмжээнд хямрал тохиолдохоос сэргийлэх боломжтой.


Цаашид даатгалын зах зээлийн эрсдэлийг тогтмол, нарийвчлал өндөртэйгөөр тооцох, мөн стресс тестийн аргачлалыг дэлгэрүүлэн судлах, тооцоололдоо ашиглах нь илүү үр дүнтэй гэж харж байна.

ЭХ СУРВАЛЖ

- ◆ Ernst N.Csiszar. “Systemic risks and the Insurance industry”
- ◆ European Central Bank. “Financial Stability Review”. 2009
- ◆ European Commission “Lessons learned from the crisis /Solvency II and beyond/”. 2020
- ◆ European Commission. “Systemic Risk in Insurance”. 2021
- ◆ European Insurance and Occupational Pensions Authority. “Systemic risk and macroprudential policy in insurance”. 2017
- ◆ Financial Stability Board. “Guidance to Assess the Systemic Importance of Financial Institutions, Markets and Instrument: Initial Considerations”. 2019
- ◆ International Association of Insurance Supervisors. “Global Insurance Market Report”. 2022
- ◆ International Association of Insurance Supervisors. “IAIS Global Insurance Market Report 2022 highlights key risks and trends facing the global insurance sector”. 2022
- ◆ Lloyd's. “Systemic Risk: Insurance Market”
- ◆ Pan European Insurance Forum. “Insurance Risk Management Response to the Financial Crisis”. 2020
- ◆ Санхүүгийн зохицуулах хороо. “Даатгалын зах зээлийн тоон мэдээлэл”. 2017–2022



Үл хөдлөх хөрөнгө худалдан авахдаа юуг анхаарах хэрэгтэй вэ?



- 1 Байршил
- 2 Чанар, хийцлэл
- 3 Ирээдүйн үнэлгээ
- 4 Ирээдүйн төлөвлөлт
- 5 Зам харилцаа
- 6 Орчин
- 7 Нийгмийн үйлчилгээ
- 8 Эрсдэл

ТАЙЛБАР

Байршил, байршил, бас дахин байршил



Батлагдсан технологийн дагуух гүйцэтгэл, чанартай хяналт хийгдсэн байх




ҮХХ нь өөрөө хөрөнгө оруулалт болдог. Ирээдүйн үнэлгээнд түүний ирээдүйн төлөвлөлт чухал



УБ хотын ерөнхий төлөвлөгөөнд хотыг зүүн баруун тийш /голчлон баруун тийш өргөжүүлэхээр/ тэлэхээр тусгажээ



Тухайн байршил хэдэн талаасаа замтай холбогдсон; Замын түгжрэл; Замын чанарыг судлах



1 км радиус дахь төлөвлөлт; мини-орчин буюу 300 метрийн радиус дахь төлөвлөлтийг судлаарай



Аюулгүй байдал, төрийн үйлчилгээ, эмнэлэг, сургууль цэцэрлэг, худалдаа үйлчилгээний төв төвлөрсөн




Газар хөдлөлт



Хөрсний эвдрэл, нуралт, үер, усны нэвчилт



Яаралтай тусламж авах боломж, орц гарц





САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №32

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ҮХХ-ийн залилангийн эрсдэлээс сэргийлцгээе



Монголд орон сууцны залилан үйлдэх нийтлэг хэлбэр:

Хуурамч бичиг баримт үйлдэх	---	Бичиг баримтын лавлагааг улсын бүртгэлээс авах
Хэт хямд үнэ санал болгох	---	Хэтэрхий таатай нөхцөл, үнэ санал болгож байгаа бол заавал шалгах
Нэг гэрээг олон хүнд зарах	---	Баримтууд үнэн зөв ч олон хүнд борлуулж, түрээслэсэн эсэхийг нягтлах.
Итгэл эвдэх	---	Найз нөхөд, хамаатан садан, дотнын /хамгийн их итгэдэг/ хүмүүс л хамгийн их залилдаг. Тиймээс хувийн сэтгэл хөдлөлөөр хандахгүй байх



ҮНДЭСЛЭЛ, БАРИМТ

Орон сууцны залилан, луйврыг 2010 онтой харьцуулахад 10 дахин нэмэгдсэн. Үүнд боловсролын бүх түвшний иргэд өртөж байгаа ба тухайн цаг үеийн мэдрэмжээс илүүтэйгээр “баталгаатай мэдээлэлтэй” харилцааг бий болгохын тулд заавал нягталж, шалгаж, баталгаажуул. Орон сууцны залиланд өртөгдсний дийлэнх нь 30–34 насныхан байгаа нь дөнгөж тодорхой хэмжээний хуримтлалтай үүсгэж эхлэх үедээ хохирогч болдог нь тун харамсалтай.

Болзошгүй эрсдэлээс
сэргийлэх



4

1

Худалдаж авах гэж буй ҮХХ-ийг эрх зүйн маргаантай эсэх талаар судлах ба лавлагаанууд авах нь аливаа эрсдэлээс хамгаална. Мөн худалдах-худалдан авах гэрээг нотариатаар гэрчлүүлж, эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай.

2

ТҮЦ машин, УБЕГ-ийн burtgel.mn гэсэн вэб сайтаас эд хөрөнгө өмчлөгч этгээдийн болон бүх төрлийн лавлагаа, мэдээллийг авах боломжтой.

3

Мөн тухайн байрны СӨХ-өөс холбогдох шаардлагатай мэдээллийг лавлах боломжтой бөгөөд үүний дараа төлбөр тооцоог хийх.

5

Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.4-д “Хуульд өөрөөр заагаагүй бол талуудын аль нэг нь хүсвэл үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно.” гэж заасан байдаг тул гэрээнд оролцогч талуудын аль нэг нь хүсээгүй, гэрээнд нотариатаар гэрчлүүлэхээр тусгаагүй бол заавал гэрчлүүлэх шаардлагагүй байдгийг анхаарах.

Туршлагатай ҮХХ зуучийн агентын нь худалдан авах, түрээслэх үйл явцад тулгарч болох аливаа эрсдэлээс таныг хамгаалж чадна. Тиймээс СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан ҮХХ-ийн зуучлалын байгууллага энэ зах зээл дээр ажилладаг тул тэдэнтэй хамтарч ажиллаж аливаа эрсдэлээс сэргийлээрэй.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ-ЫН ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ХЭВЭЭР ХАДГАЛАХ ШИЙДВЭР ГАРГАЛАА.



2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр АНУ-ын Холбооны нөөцийн сангаас бодлогын хүүг 5.25– 5.50 хувьд хэвээр үлдээхээ мэдэгдлээ. 2022 оны 3 дугаар сараас хойш нийтдээ 10 гаруй удаа дараалан Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ өсгөөд байсан бол энэ удаа 5.25–5.50 хувьд хэвээр үлдээхээр шийдсэн нь 2022 оны гуравдугаар сард эхэлсэн бодлогын хүүгийн өсөлт үндсэндээ зогсож байгааг шинжээчид онцолж байна.

АНУ-ын Холбооны нөөцийн сангийн тэргүүн Жером Пауэллын мэдээлснээр, бодлогын хүүг цаашид ч өсгөж болзошгүй бөгөөд инфляцыг эргүүлэн хоёр хувьд хүргэх бодлого баримтлах юм байна. Тэрээр “Мөнгөний бодлого хангалттай хэмжээнд чангарсан эсэхэд итгэлгүй хэвээр байгаа ч бодлогын хүүг хэвээр хадгалах нь хөрөнгө оруулагчдад бол ногоон гэрэлтэй” гэж мэдэгджээ. Шинжээчдийн таамаглаж буйгаар Холбооны нөөцийн сан 2024 онд бодлогын хүүг 4.5–4.75 хувьд, 2025 онд 3.5–аас доош хувьд хүртэл бууруулна гэж таамаглаж байна.

Эх сурвалж: www.reuters.mn

АНГЛИЙН ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ХЭВЭЭР ХАДГАЛАХ ШИЙДВЭР ГАРГАСНЫ ДАРАА АНГЛИЙН БИРЖИЙН ХУВЬЦААНУУДЫН ХАНШ ӨСӨВ.



2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Английн Төв банк бодлогын хүүгээ 5.25 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасны дараа Европын томоохон компаниуд хөрөнгө оруулагчдад улирлын тайлангаа танилцуулсан. Энэхүү үйл явдлын дараа Европын голлох хувьцааны индексүүд болох “Stoxx Europe 600” индекс 1.58 хувиар, Английн “FTSE 100” индекс 1.42 хувиар, Германы “DAX” 1.48 хувиар, Францын “CAC 40” 1.85 хувиар, Италийн “FTSE MIB” 1.77 хувиар, Испанийн “IBEX 35” 2.04 хувиар тус тус өсжээ.

Эх сурвалж: www.reuters.mn

АНУ-ЫН ИНФЛЯЦ 3.1 ХУВЬ ХҮРТЭЛ БУУРЛАА.

АНУ-ын Хөдөлмөрийн яамнаас хэрэглээний үнийн индексийн 11 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 хувиар өссөн үзүүлэлттэй байгааг онцолжээ. Мөн инфляц 2023 оны 10 сард суурь инфляц 3.2 хувь байсан бол 11 дүгээр сард 3.1 хувь хүртэл буурчээ. Энэ нь сүүлийн таван сарын инфляцын хамгийн доод түвшинд хүрсэн үзүүлэлт юм.



Энэхүү мэдэгдлийн дараа АНУ-ын хөрөнгийн биржийн томоохон индексүүд сүүлийн 15 сарын дээд цэгтээ хаагдсан бөгөөд бодлогын хүүтэй уялдуулсан хоёр жилийн төрийн сангийн өгөөж хоёр долоо хоногийн хамгийн доод түвшинд буюу 4.72 хувьд хүрч зургаан валюттай сагстай харьцах ам.долларын индекс сүүлийн 15 сарын хамгийн доод түвшинд хүрлээ.

Эх сурвалж: www.ft.mn



ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ УНАСНЫ ДАРАА АЗИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХУВЬЦААНЫ ХАНШ УНАЖЭЭ.

ВАШИНГТОН, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр үл хөдлөх хөрөнгийн фирмүүдийн бууралтаас шалтгаалан Хятадын хөрөнгийн зах зээл унасны дараа Ази, Номхон далайн орнуудын хувьцааны ханш унажээ. Япон улсын үйлчилгээний салбарын инфляц сүүлийн 45 сарын дээд хэмжээнд хүрсэн байна. Японы үйлдвэрлэгчийн үнийн индекс 10 дугаар сард 2.3 хувиар өссөнөөр 2020 оны нэгдүгээр сараас хойших хамгийн дээд түвшинд хүрсэн нь өмнөх сарын үзүүлэлтээс 2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хонконгийн Hang Seng индекс 0.12 хувиар буурсан бол Хятадын эх газрын индексүүд буурсан үзүүлэлттэй хаагдаж, CSI 300 индекс 0.74 хувиар унаж, 3,511.94 нэгжид хүрчээ. Японы Nikkei 225 индекс мөн 0.53 хувиар буурч, 33,447.67 нэгжид хүрснээр долоодугаар сарын 3-ны өдөр 33 жилийн дээд цэгтээ хүрч байсан 33,753.33 нэгжээс доошилжээ. Харин Торix индекс 0.38 хувиар буурч, 2,381.76 нэгжид хүрсэн байна. Өмнөд Солонгосын Kospi индекс бага зэрэг буурч, 2,495.66 нэгжид хүрсэн бол жижиг хувьцаануудын ханшийг харуулдаг Kosdaq индекс 0.58 хувиар буурч 810.25 нэгжид хүрсэн байна.

Эх сурвалж: www.reuters.mn



ЕВРОПЫН ТӨВ БАНКНААС БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ХЭВЭЭР ХАДГАЛАХ ШИЙДВЭР ГАРГАЛАА


ФРАНКУРТ, 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Европын төв банкны удирдлагуудын хурлаас бодлогын хүүгээ 4 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Төв банкны зүгээс бодлогын хүүгээ хэвээр хадгалснаар инфляцыг зорилтот 2 хувьд хүргэхэд томоохон дэмжлэг үзүүлнэ гэж үзсэн байна. Мөн Европын төв банкнаас 2026 он хүртэлх эдийн засгийн төсөөлөлд инфляц аажмаар бууж, дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх хандлага ажиглагдсаныг онцолжээ. Европын Төв банкны тэргүүн Кристин Лагард хэвлэлийн өгсөн мэдээллийн үеэр “Үнийн өсөлтийн аюул” илүү тогтворжиж байгаа ч эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх эрсдэлүүд өндөр хэвээр байгаа бөгөөд Төв банкны зүгээс мөнгөний бодлогын үр нөлөө эдийн засагчдын таамаглаж буйгаас өндөр байвал эдийн засгийн өсөлт удаашрах төлөвтэйг магадлалтайг онцлов.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,719.19 -0.36 (-0.01%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/

32,620.75 -349.80 (-1.06%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,576.36 -72.62 (-0.95%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

14,813.92 +52.32 (+0.35%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн Зохицуулах Хороо



@FRC_of_Mongolia